



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/109

Хажуу шинэ ус

Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1, 48.2.4, 48.2.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.3 дахь хэсэг, үнэлгээний хорооны 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 05 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Говь-Угтаал сумын төвийн гэрэлтүүлэг”-ийн ажил 152,896,724 (нэг зуун тавин хоёр сая найман зуун ерэн зургаан мянга долоон зуун хорин дөрөв) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Сайжрах Шилтгээн” ХХК шууд гэрээ байгуулах эрхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д олгосугай.

2. “Говь-Угтаал сумын төвийн гэрэлтүүлэг”-ийн ажлыг захиалагчийн гаргасан саналд үндэслэн чанар сайтай хийж гүйцэтгэхийг “Сайжрах Шилтгээн” ХХК-д даалгасугай.

3. “Сайжрах Шилтгээн” ХХК ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлын явцад гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох), Санхүү албаны дарга (Н.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Т.АРИУНАА

482401100